

**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД
ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ**

2026 оны 02 дугаар сарын 06

Дугаар БА-038/2026

Улаанбаатар хот

Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын нийслэлийн Чингэлтэй дүүргийн 9 дүгээр хороонд баригдсан өндөр төвөгшилтэй ангиллын зорьтой, 4 (дөрөв) автомашины зогсоолтой, 15 (арван тав) давхар 1 (нэг) блок бүхий хүчин чадал бүхий оффис, үйлчилгээний зориулалттай барилга байгууламжид Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/503 дугаар захирамжийн шийдвэрээр байгуулагдсан 15 хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2025 оны 12 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

2.1. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний 2020/08/14 огноо, 0007140 092/2020 дугаар;

2.2. Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар: ХАТ-01/14

2.3. Захиалагч: Иргэн Чойжилжав овогтой Баатарсүрэн оноосон нэр, УХ66120918 регистрийн дугаар, хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 11 дүгээр хороо, Белла виста хотхон, 700-801 байр, 99112408 холбоо барих утас, baatarsuren@m1000.mn цахим хаяг;

2.4. Барилгын ажлын гүйцэтгэгч: Сивил инженеринг мастер констракшн ХХК оноосон нэр, 90111814899 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 6525695 регистрийн дугаар, БУ12-1071/25 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15 дугаар хороо, Хүннү-2222 хотхон, 110, 10д байр, 94007548 холбоо барих утас, enkhamar@gmail.com цахим хаяг;

2.5. Барилгын ажлын Туслан гүйцэтгэгч байгууллага: Байхгүй.

2.6. Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: Хатанбаатар ХХК оноосон нэр, 9011039098 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 2090473 регистрийн дугаар, ЗТ11-473/24 зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар, хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 2 дугаар хороо 45/4 байр 601 тоот, 88073609 холбоо барих утас, info@khatanbaatar.mn цахим хаяг;

2.7. Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага: Иргэн Чойжилжав овогтой Баатарсүрэн оноосон нэр, УХ66120918 регистрийн дугаар, хаяг:

Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 11 дүгээр хороо, Белла виста хотхон, 700-801 байр, 99112408 холбоо барих утас, baatarsuren@m1000.mn цахим хаяг;

2.8. Барилга байгууламжийн төлөв байдал: **Шаардлага хангасан;**

Гурав. Дүгнэлтийн хэсэг

✓ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул

Барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй тул

- Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангаагүй тул

3.1. Иргэн Ч.Баатарсүрэнгийн захиалгатай, Чингэлтэй дүүргийн 9 дүгээр хороонд баригдсан өндөр төвөгшилтэй ангиллын зорьтой, 4 (дөрөв) автомашины зогсоолтой, 15 (арван тав) давхар 1 (нэг) блок бүхий хүчин чадал бүхий оффис, үйлчилгээний зориулалттай барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:

Энэ барилга байгууламжийн барилгын ажил нь зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

3.2. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

- а).барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивд, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад ... хоногийн дотор багтаан шилжүүлэх;
- б).барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

3.3. Ашиглагч байгууллагад:

- а).барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;
- б).барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;


ХЯНАЛТ ША
ГАЗА
Барилга байгууламж
орлуулах к

в).барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.

3.4. Комиссын акт 3 хуудас, хуралдааны тэмдэглэл 5 хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт 30 хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримт материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1. Чингэлтэй дүүргийн 9 дүгээр хороонд баригдсан өндөр төвөгшилтэй ангиллын зоорьтой, 4 (дөрөв) автомашины зогсоолтой, 15 (арван тав) давхар 1 (нэг) блок бүхий хүчин чадал бүхий оффис, үйлчилгээний зориулалттай барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан:



Иргэн Ч.Баатарсүрэнгийн захиалгатай,
Чингэлтэй дүүргийн 9 дүгээр хороонд баригдсан
зоорьтой, 15 давхар 1 блок оффис, үйлчилгээний барилга

Комиссын дарга:
Хяналт шалгалтын газрын
Барилга байгууламжийн ашиглалт,
бүртгэлийн хэлтсийн даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч




(А.Мөнгөн)

Нарийн бичгийн дарга:
Захиалагч иргэн

(Ч.Баатарсүрэн)

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгаврын биелэлтийн хуудасны хамт хүчинтэй.



ИРГЭН Ч.БААТАРСҮРЭНГИЙН ЗАХИАЛГАТАЙ, ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН 9 ДҮГЭЭР
ХОРООНД БАРИГДСАН ЗООРЬТОЙ, 15 ДАВХАР ОФФИС, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
БАРИЛГЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2026 оны 12 дугаар сарын 19

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН

ГАЗАР

Иргэн Ч.Баатарсүрэнгийн захиалгатай, Чингэлтэй дүүргийн 9 дүгээр хороонд баригдсан өндөр төвөгшилтэй ангиллын зоорьтой, 4 (дөрөв) автомашины зогсоолтой, 15 (арван тав) давхар 1 (нэг) блок бүхий хүчин чадал бүхий оффис, үйлчилгээний зориулалттай барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах комиссын хурал 2025 оны 12 дүгээр сарын 19-ний өдрийн 13:00 цагт тус газарт 15 гишүүний бүрэлдэхүүнтэй эхэлж, 15:00 цагт дуусав.

Хуралд:

1. Комиссын дарга:
Хяналт шалгалтын газрын
Барилга байгууламжийн ашиглалт,
бүртгэлийн хэлтсийн даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Мөнгөн
2. Нарийн бичгийн дарга: Захиалагч
Иргэн Ч.Баатарсүрэнг төлөөлж төслийн удирдагч Б.Дөлгөөхөн
3. Хяналт шалгалтын газрын Барилгын стандарт,
аюулгүй байдал хяналтын хэлтсийн
Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч Т.Цолмонуяа
4. Хяналт шалгалтын газрын Дэд бүтцийн стандарт,
хяналтын хэлтсийн
Эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагч Э.Цогзолмаа
5. Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-ийн
Шинэ хэрэглэгчийн холболтын хэлтсийн дарга Б.Эрдэнээ
6. Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн
Техник хяналтын инженер Ц.Наранцацрал
7. Мэдээлэл холбоо сүлжээ ТӨХК-ийн
Улаанбаатар хотын сүлжээний газрын
Технологийн удирдлага төлөвлөлтийн газар
Чанар хяналтын хэлтсийн мэргэжилтэн Н.Даваадэмид
8. Ус сувгийн удирдах газрын Хэрэглэгчдэд үйлчлэх алба
Борлуулалт, мэдээлэл лавлагааны инженер Д.Отгонжаргал
9. Нийслэлийн Онцгой байдлын газрын
Гал түймэртэй тэмцэх хэлтсийн Барилгын зураг төслийн
хяналтын ахлах дэслэгч Е.Лхагвадорж
10. Үндэсний төв архивын
Зураг төслийн баримтын архивын архивч Э.Шижиртуяа
11. Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ийн
Барилгын чанар аюулгүй байдлын
Хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Жаргал
12. Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоо,
Хүртээмжийн үнэлгээний ажилтан Д.Ганбат

13. Ашиглалт хариуцах байгууллага,

Ашиглалтын инженер

У.Ганхуяг

14. Зураг зохиогч, Хатанбаатар ХХК-ийн захирал

Ц.Мөнхбаяр

15. Гүйцэтгэгч, Сивил инженеринг мастер констракшн ХХК

Гүйцэтгэх захирал

Ц.Энх-Амар

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Чингэлтэй дүүргийн 9 дүгээр хороонд баригдсан өндөр төвөгшилтэй ангиллын зорьтой, 4 (дөрөв) автомашины зогсоолтой, 15 (арван тав) давхар 1 (нэг) блок бүхий хүчин чадал бүхий оффис, үйлчилгээний зориулалттай барилгын ажлын баримт бичгийн бүрдэл, барилгын ажлын гүйцэтгэл нь ашиглалтанд оруулах шаардлага хангасан эсэх талаар хэлэлцэв.

СОНССОН НЬ:

Комисст ажилласан гишүүд барилга байгууламжийн зураг төсөл, баримт бичиг, барилга угсралтын гүйцэтгэлийг хянаж дараах саналуудыг гаргав.

Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч **А.Мөнгөн**

- БТХ-ийн 14.3, 14.6-ын дагуу гүйцэтгэгч чанарын баталгаа бичиг ирүүлэх;
- Зохиогч өөрчлөлт бүрийг тусгасан дүгнэлт бичих;

Хяналт шалгалтын газрын Барилгын стандарт, аюулгүй байдал хяналтын хэлтсийн Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч **Т.Цолмонтуяа**

- Барилгын ажилд зохиогчийн хяналт тавих дүрэм БНБД 11-04-16 дагуу зохиогч дүгнэлтэндээ өөрчлөлтийг тусгаж ирүүлэх;
- БТХ-ийн 14.3 14.6 чанарын баталгаа гаргах;
- Утаагүйжүүлэгч аваарын 2 дахь гарцыг шийдэх, Гадна аваарын метал шат угсарч гэрэл зургаар ирүүлнэ;
- Техникийн давхрын хүчин чадал нэмэгдүүлсэн. ЗТХ-ийн дагуу гүйцэтгэгч арга хэмжээ тооцуулах (торгууль)
- Хот байгуулалт хотын стандартын мэдээллийн санд 2019 онд ашиглалтанд оросн БУ19-688112 (175) дугаар авсан байна. Тайлбар авч ирүүлэх;
- БТХ-ийн 40.1.2 заалтын хэрэгжилтийг хангуулж бетоны бат бөх шоо дүгнэлт ирүүлнэ;
- Ажлын 14 хоногийн дотор үүрэг даалгаврыг биелүүлэх.

Хяналт шалгалтын газрын Дэд бүтцийн стандарт, хяналтын хэлтсийн Эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагч **Э.Цогзолмаа**

- 1 хэлхээний огтолгооны цэг өөрлүүлсэн албан бичгийг шалгуулах (498/2019 сунгалт.тех.н)
- Дулаан хангамж дулаан механикийн зураг төслийг батлуулах;
- Гадна шугам угсарсан актыг хангагч байгууллагаар баталгаажуулах;
- Дотор халаалт, агаар тийг угсарсан актыг баталгаажуулах;
- Барилгын дээвэр дээрх АС-г шахтны дифлектрээс бохирын үнэр гаргагч хоолойг өндөрлөж дулаалга малгайвч хийх;



- Гадна дулааны худгийг цэвэрлэх, фото зургаар шалгуулах, шугам сүлжээг дулаалж өнгийн туузаар ороох;
- Ашиглагч байгууллагад хүлээлгэж өгсөн актыг шалгуулах;
- Хими ус цэвэрлэгээний төхөөрөмжийг хэвийн ажиллагаанд оруулах;
- Халаах хэрэгсэлд термостат винтель суурьлуулах;
- Зохиогч, захиалагч дүгнэлтээ шинэчилэж ирүүлэх;
- Усны нөөцийн савыг шинжилгээнд хамруулж улсын байцаагчийн дүгнэлт гаргуулах;

Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-ийн Шинэ хэрэглэгчийн холболтын хэлтсийн дарга **Б.Эрдэнэ**

- Гадна дулаан, дулаан механикийн зураг зурж батлуулах;
- Гадна шугам, узель, дотор системийн акт баталгаажуулах;
- Халаалтын 2-р хэлхээг 1-р хэлхээ болгосон албан тоот хавсаргаж үзүүлэх;
- Хими ус цэвэрлэгээний төхөөрөмж ашиглалтанд оруулах;
- Даралт барих систем ашиглалтанд оруулах;

Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн Техник хяналтын инженер **Ц.Наранцацрал**

- Дотор цахилгаан хүчит төхөөрөмжийн ил далд ажлын акт, туршилт хийсэн шалгасан актанд гарын үсгийн бүрдлийг бүрдүүлэх;
- Давхар дундын нийтэд суурилуулсан CHS160 тоолуурын хангагч байгууллагатай зөвшилцөх;
- Ерөнхий шитний өрөөний байршил өөрчлөгдөж, босоо магистрал 3-4 давхар дунд 1 татагдсан байгаа нь оффис үйлчилгээний зориулалтын хэрэглээний ачааллыг бүрэн хангаж байгаа талаар авторын дүгнэлтэд тусгуулах;
- Барилга баригдах үеийн цахилгааны төлбөрийг бүрэн төлсөн байх;
- Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналыг дэвшүүлж байна.

Мэдээлэл холбоо сүлжээ ТӨХК-ийн Улаанбаатар хотын сүлжээний газрын Технологийн удирдлага төлөвлөлтийн газар Чанар хяналтын хэлтсийн мэргэжилтэн

Н.Даваадэмид

- Холбоо дохиоллын зургийг гүйцэтгэлээр хянуулж баталгаажуулах;
- Давхрын самбар дахь кабель шугам цэгцэл залгааг стандартын болгох;
- В1 зоорийн давхарт кабель шугамын тавиур хийж гүйцэтгэх, хаягжуулах
- Айлуудын контурын өрөөнүүд өрөөний самбар сольж стандартын болгох;
- Дуут харилцуурыг дүрст дотофон системи суурилуулах өгөх;
- Давхрын самбар хаягжуулж өгөх;

Ус сувгийн удирдах газрын Хэрэглэгчдэд үйлчлэх алба Борлуулалт, мэдээлэл лавлагааны инженер **Д.Отгонжаргал**

- Техникийн нөхцөлийг чиглэл өөрчлөх /ангилал/
- Нөөцийн савны хэмжээ багассан;
- Үйлчилгээний ресторанд тос баригч суурьлуулах;
- Дээврийн борооны усны хаялгыг трассыг өөрчлөх /бохир усны худагруу орохоор хийгдсэн/, цэвэр бохир усны далд ажлын актууд нөхөж үзүүлэх;

- Гадна худагт галын гидрант суурилуулах;
- Цэвэр усны батлагдсан бохир ажлын зургийн дагуу хийгдээгүй;
- Цэвэр усны худагт сосонк хийх; бохир усны худагт чигжээс хийсэн эсэх;
- Бохир усны худаг тунатай, уналт хийх, ховил татах фото зураг хавсаргах;
- Нөөцийн савны дээгүүр бохир усны шугамын трасс таарсан;
- Гүйцэтгэлийн зураг CD өгөх;
- Бохир цэвэр усны шугам огтолцсон эсэх фото зураг хавсаргах;
- 1500мм худаг өөрчлөх камер худаг болгосон эсэх;
- БУХ-6 , БУХ-4 нөхөж үзүүлэх;

Нийслэлийн Онцгой байдлын газрын Гал түймэртэй тэмцэх хэлтсийн Барилгын зураг төслийн хяналтын ахлах дэслэгч **Е.Лхагвадорж**

- РК Галын дотор усны даралтат цэгийн хоолой хошууг чангалах, даралттай усаар хангах;
- Тагтанд байрлах аваарыг шатыг зураг төслийн дагуу хийх;
- Гүйцэтгэлийн зургийг хянуулах;
- Авто зогсоолыг зураг төслийн дагуу хийх;
- Холбоо дохиоллын систем-г гүйцээж хийх;
- Шаталтын бүтээгдэхүүн сорих өгөх, системийг хэвийн үйл ажиллагаанд оруулах;

Үндэсний төв архивын Зураг төслийн баримтын архивын архивч **Э.Шижиртуяа**

- Ил далд ажлын актыг бүрэн бүрдүүлэх баталгаажуулах;
- Барилга угсралтын ажлын гүйцэтгэсэн ажлыг гүйцэтгэсэн тэмдэглэлийг баталгаажуулах;
- Архивт баримт бичиг хүлээлгэн өгөх нийтлэг жагсаалтын дагуу баримт бичиг ажлын зураг актыг бүрэн бүрдүүлэх баримт бичгийн хуудас дугаарлах дотоод товъёог үйлдэх;
- Баримт бичиг болон ажлын зургийн эх хувийг архивд хүлээлгэн өгөх;

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ийн Барилга, барилгын чанар аюулгүй байдлын хэлтсийн ахлах мэргэжилтэн **Б.Жаргал**

- Барилгын тухай хуулийн дагуу норм норматив алд төлбөр төлсөн бүрийг шалгуулах
- Барилгад ашигласан барилгын материал гарал үүсэл, чанар тохирлыг гэрчилгээ, тусгай зөвшөөрөл зэргийг шалгуулах
- Чанарын баталгаа гаргаж үзүүлэх

Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоо, Хүртээмжийн үнэлгээний ажилтан **Д.Ганбат**

- Гадна авто зогсоолд хөгжлийн бэрхшээлтэй иргэн машин тавих зогсоол нэмэж босоо болон хэвтээ тэмдэглэгээ хийх
- Оффисын болон үйлчилгээний шатнаас гарах гарц хүртэл хараагүй иргэдэд зориулсан хөтөг зам хийх
- Орох хаалганаас цахилгаан шат хүртэл хараагүй иргэдэд зориулсан чиглүүлэгч юмуу хөтөг зам хийх

- 2 болон 4 давхарт хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан ариун цэврийн өрөөг хийж стандартыг дагуу тоноглох
- Цахилгаан шатыг монгол хэлээр давхар зарладаг болгох
- Б1 давхрын авто зогсоолд шатаар тэргэнтэртэй иргэн зорчих боломжгүй байгаа тул уг шатыг налуу зам болгох
- Ариун цэврийн өрөөний нойлын өрөөний зам талбайг тэргэнцэртэй иргэн үйлчлүүлэхэд саадтай байгаа тул нойлыг эргүүлэн нойлын угаалтуур өөрчлөх
- Дээрхи үүрэг даалгаврын биелэлтийг фото зураг болон видео бичлэгээр өгөх

Ашиглалт хариуцах байгууллага: ашиглалтын инженер **У.Ганхуяг**

- Дулааны техник нөхцөл болон холбогдох бичиг баримт зураг зөрчилтэй;
- Ариутгал татуургийг худаг дулаалга байхгүй;
- Хими цэвэрлэгээний ус цэвэрлэгээний бүрэн ажилгаанд оруулаагүй холболт байхгүй;

Зураг зохиогч байгууллага: Хатанбаатар ХХК-ийн архитектор **Ц.Мөнхбаяр**

- Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Гүйцэтгэгч байгууллага:

Сивил инженеринг мастер констракшн ХХК-ийн гүйцэтгэх захирал **Ц.Энх-Амар**

- Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Захиалагч: Иргэн Ч.Баатарсүрэнг төлөөлж төслийн удирдагч **Б.Дөлгөөхөн**

- Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

ИН

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Иргэн Ч.Баатарсүрэнгийн захиалгатай, Чингэлтэй дүүргийн 9 дүгээр хороонд баригдсан өндөр төвөгшилтэй ангиллын зорьтой, 4 (дөрөв) автомашины зогсоолтой, 15 (арван тав) давхар 1 (нэг) блок бүхий хүчин чадал бүхий **оффис**, үйлчилгээний зориулалттай барилга байгууламжийг байнгын ашиглалтанд оруулах комиссын гишүүдийн гаргасан үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах, биелэлтээр комиссын дүгнэлтийг баталгаажуулж, ашиглалтад оруулахаар шийдвэрлэв.

Танилцсан:

Хяналт шалгалтын газрын
Барилга байгууламжийн ашиглалт,
бүртгэлийн хэлтсийн даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч

Тэмдэглэл хөтөлсөн:

Захиалагч иргэн Ч.Баатарсүрэнг
төлөөлж төслийн удирдагч


(А.Мөнгөн)


(Б.Дөлгөөхөн)


9024041948
8311331 СБТ24868